


Монгол улсын газрын тосны салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт

**Монгол улсад газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа
компаниуд**

д/д	Талбайн нэр	Гэрээлэгч	Хөрөнгө оруулагчийн харьяалал
1	Тосон-Уул XIX	Дачин Ойл Фийлд Лимитед	БНХАУ
2	Буйр ХХП		
3	Тамсаг ХХИ		
4	1997 оны гэрээт	Доншен газрын тос компани	БНХАУ
5	Матад ХХ	ПетроМатад ХХК	Монгол улс
6	Тариач XV	Чайна Голден Сий Петролеум Инвестмент	БНХАУ
7	Нялга XVI	Шаман Ресурсес Лимитед	Канад
8	Цагаан-Элс XIII	DWM Петролеум AG	Швейцарь улс
9	Зүүнбаян XIV		
10	Галба XI	Зон Хэн Юу Тиан Лимитед	БНХАУ
11	Сулинхээр ХХIII	Шунхлай энерги ХХК	Монгол улс
12	Борзон VII	М Си Эс Холдинг ХХК	Монгол улс
13	Хөх нуур XVIII	Эн Пи Ай ХХК	БНХАУ
14	Төхөм X (хойд)	Сансарын геологи хайгуул ХХК	Монгол улс
15	Цайдам ХХVI		
16	Богд IV	КапКорп Монголиа	Их Британий Каймэний арал улс
17	Онги V		

**Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан
компаниудын харьяалал**




■ Монгол

■ Хятад


■ Бусад

12 компани хайгуулын 17 талбайд БХГ байгуулсан


**Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт
(оноор, сая ам.доллар)**





**Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт
(компаниар, мянган ам.доллар)**



Улсын төсөвт оруулсан орлого (оноор, сая төгрөг)




**Улсын төсөвт төвлөрүүлсэн түүхий тосны
борлуулалтын орлого
(компаниар, тэрбум.төг)**




**Газрын
тосны
олборлол
т, экспорт
(оноор,
мянган
баррель)**



**Газрын тосны олборлолт, экспорт
(компаниар, мянган баррель)**



Газрын тосны хайгуул, олборлолтын зориулалтаар
өрөмдсөн цооног (оноор)




Газрын тосны хайгуул, олборлолтын зориулалтаар өрөмдсөн цооног (компаниудаар)



Хоёр хэмжээг эст чичирхийллийн хайгуул (компаниудад, тууш км)

Улсын хэмжээнд 19,000 тууш км хоёр хэмжээст чичирхийллийн хайгуул гүйцэтгэжээ


**Гурван хэмжээст чичирхийллийн хайгуул
(компаниудаар, кв км)**



Улсын хэмжээнд 5920 кв км талбайд гурван хэмжээст чичирхийллийн хайгуул хийжээ

Газрын тосны нөөцийн талаар

Тосон-Уулын ордын газрын тосны нөөцийн тооцоо, орд ашиглах эдийн засгийн үнэлгээний тайланг ЭБЭХЯ-ны Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын 2010 оны 41



тоот тушаалаар тус ордын 14 блокт бодсон газрын тосны баталгаат нөөцийг 119.02 сая тонн, үүнээс газрын тосны ашиглалтын баталгаат нөөцийг 13.67 сая тонн; тосонд ууссан хийн баталгаат нөөцийг 2 тэрбум 589.0 сая м³, үүнээс тосонд ууссан хийн ашиглалтын баталгаат нөөцийг 296 сая м³—ээр тус тус Монгол Улсын эрдэс баялгийн нөөцийн нэгдсэн санд бүртгэж авсан.

Мөн Тосон уулын ордын бусад 29 блокын хэмжээнд бодсон газрын тосны магадтай нөөцийг 74.54 сая тонн, тосонд ууссан хийн магадтай нөөцийг 4 тэрбум 692.0 сая м³, 8 блокын хэмжээнд тооцоолсон газрын тосны боломжит нөөцийг 52.78 сая тонн, тосонд ууссан хийн боломжит нөөцийг 2 тэрбум 987.0 сая м³—ээр тус тус Монгол Улсын эрдэс баялгийн нөөцийн нэгдсэн бүртгэлээ.

Газрын тосны олборлолтын үйл ажиллагааны хүрээнд хийгдэж буй ажил

Петрочайна Дачин Тамсаг ХХК Тосон-Уулын ордод түүхий тос олборлох, цуглуулах, цэвэршүүлэх, хадгалах, ачих, буулгах ил байгууламжийн зураг төслийг боловсруулж, Монгол Улсын шинжээчдээр экспертиз хийлгэж байна.



2010 онд энэхүү ил байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Ил байгууламжийг ашиглалтанд оруулснаар экспортын түүхий тосон дахь ус, хий, механик хольцын агууламжаас хамааралтай зөрүүг бүрэн шийдэх боломжтой болох юм.

**Үндсэн нөхцөлийг нь тохирч үзэглэсэн
бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд**

д/д	Талбайн нэр	Захиалга ирүүлсэн	Хөрөнгө оруулагчийн
-----	-------------	-------------------	---------------------

			харьяалал
1	Баянтүмэн XVII	Магнай трейд ХХК	Монгол улс
2	Дарьганга XXIV	Алекспро Инвестмэнт Лтд ХХК	БНХАУ
3	Төхөм X (урд)	Монголын Алт ХХК	Монгол улс
4	Хонгор VIII	Эн Пи Ай ХХК	БНХАУ
5	Эргэл XII	Эм Өү Өү Ай Си Өү ХХК	ХонгКонг
6	Нэмэгт VI	Тэнгригрупп ХХК	Монгол улс
7	Шарга III	Тэнгригрупп ХХК	Монгол улс
8	Номгон IX	Сансарын геологи хайгуул ХХК, Айвенхоу Энержи Инк ХХК	Монгол улс

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй шатахуун түгээх станц, агуулахын тоо, хүчин чадал

Үйлчилгээний цэгийн төрөл	Агуулах, ШТС-ын тоо	Савны тоо
ШТС	1126	3192
Агуулах	103	4338

Улсын хэмжээний газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг 100 гаруй агуулах (үүнээс 20 агуулах консервацид), 1100 орчим шатахуун түгээх станц (Үүнээс 162 ШТС Улаанбаатар хотод), 10 орчим хийн байгууламжаар дамжуулан хангаж байна. “НИК” ХК улсын хэмжээний газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг дангаар хангаж байсан үетэй харьцуулбал ШТС-ын тоо буюу түгээх хүчин чадал 2.5 дахин өссөн нь шатахуун, тосолгооны материалаар тасралтгүй найдвартай хангах нөхцөл дээшлэн, үйлчилгээ хэрэглэгчидэд ойртсон чухал алхам болсон юм.

Техник технологийн байдал

2003, 2006, 2007 онуудад Үйлдвэр худалдааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд нарын хамтарсан тушаалаар улсын хэмжээний бүх агуулах, ШТС-уудад, Монгол Улсын шадар сайд, Эрдэс баялаг, Эрчим хүчний сайдын хамтарсан 37/166 тоот тушаал, удирдамжийн дагуу 2009 оны 07 дугаар сарын 24-нөөс 2009 оны 10 дугаар сарын 15-ны хооронд хүн амын нягтаршил ихтэй хот, суурин газар болон төв замын дагуу үйл ажиллагаа явуулж буй газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, хийн байгууламжуудад түвшин тогтоох улсын үзлэгүүдийг тус тус явуулж, яам Засгийн газрын түвшинд танилцуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ирлээ.

Үзлэгээс үзлэгийн хооронд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн техник технологийн түвшин зохих хэмжээгээр дээшилж, шинэ техник, шинжлэх ухааны ололтууд нэвтэрсээр байгааг тэмдэглэх нь зүйтэй. Үзлэгийн дүнгээс үзэхэд зарим компаниуд, тухайлбал: Жаст-Ойл, Магнай трейд, Петровис ХХК-ууд галын аюулаас хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг багасгахад чиглэгдсэн, галын аюулгүйн зай хэмжээний нормыг багасгаж болохуйц, олон улсад ашиглагдаж буй шинэ техник технологийг хүн ам, барилга байгууламжийн нягтаршил ихтэй, ялангуяа Улаанбаатар хот, аймгийн төвүүд дэхь ШТС-уудад нэвтрүүлэх талаар

нилээд
давхар

анхаарч
ханатай

байна. Үүнд:
сав,

түвшин мэдрэх автомат, механик төхөөрөмжүүд,
гоожилт шүүрэлтгүй буулгах шинэ тоноглол,
түгээгүүр механик гэмтэл /мөргөх/-д өртөхөд асгалт гоожилт гаргахгүй хэрэгсэл (таслагч клапан),
түгээгүүрийн шлангийг тээврийн хэрэгсэл тохиолдлоор таслах, чирэх нөхцөлд
гоожуулахгүй хаах аюулгүйн таслагч клапангууд;
автомашиньг шатахуунаар цэнэглэх үед бакнаас гарах шатахуун агаарын холимог хийг
сав руу буцаах хийн буцаах систем;
автоцистернээс шатахуун буулгах үед савнаас уурших хийн холимогийг автоцистерний
торх руу буцаах системд холбох боломжийг бүрдүүлэх зэрэгт хөрөнгө оруулалтын
ажлуудыг гүйцэтгэж байна.

Үүнтэй уялдуулан зарим Барилгын норм ба дүрмийг шинээр боловсруулах, стандартыг шинэчлэн тодорхой болгох шаардлага ч урган гарч байгаа юм.

Харин ШТС-уудын 20-оод хувь нь Газрын тухай, Барилгын тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Галын аюулгүй байдлын тухай, Байгаль орчны тухай, Хэмжлийн нэгдмэл байдлын тухай Монгол Улсын хуулиуд болон ШТС-ын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага MNS 4628-98, Шатахуун хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачилал MNS 4633-2006 стандартуудыг зөрчин үйл ажиллагаа явуулж байгаагаас байгаль орчныг бохирдуулах нөхцлийг бүрдүүлж, галын болон тэсрэх аюул осол гарахгүй гэх баталгаагүй, техникийн шинэчилэл хийх тал дээр хангалтгүй ажиллаж байсан дүн гарсан бөгөөд үзлэгийн мөрөөр дээрхи дутагдлыг арилгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээд байна. Зөрчил, дутагдалаа арилгах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байгаа зарим компани, аж ахуйн нэгж байгууллагуудад МХЕГ-тай хамтран зөрчлийг арилгуулах зарим ажлыг ч эхлүүлээд байна.

Сав паркийн багтаамж нэмэгдүүлэх талаар

“Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 48 дугаар тогтоолоор Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийг бууруулах, уг бүтээгдэхүүний хангалтыг хэвийн, найдвартай, тасралтгүй болгох ажлын хүрээнд нөөцийг хадгалахад нэмж шаардагдах сав барих ажлыг 2009 онд багтаан зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан билээ.

Үүний дагуу төмөр замын дагуу байрлалтай болон газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ өндөртэй газрууд болох Улаанбаатар, Дархан-Уул, Говьсүмбэр аймгуудад шинээр агуулах барих, Замын-Үүд дэх шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийг өргөтгөх замаар 60 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах хүчин чадал бүхий сав паркийн багтаамж буй болгох ажлыг зохион байгуулах тал дээр анхаарч зураг төслийг боловсруулах ажлыг дуусган барилга угсралтын ажлын хөрөнгө



оруулалтыг 2010-2012 оны улсын төсвийн төсөлд тусгуулахаар төлөвлөөд байна.

Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоо

“Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дорнод аймагт газрын тосны бүтээгдэхүүний иж бүрэн шинжилгээ хийх, Дархан-Уул, Орхон, Ховд, Говь-Сүмбэр, Замын-Үүдэд Төлөөлөгчийн газар, түүний дэргэд газрын тосны бүтээгдэхүүний хүлээн авах болон түгээх үеийн чанарын хяналтын шинжилгээ хийх хүчин чадал бүхий лабораториудыг байгуулан ажиллаж байна.

Цаашид Монгол Улсын хэмжээнд Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль болон холбогдох бусад хуулийг хэрэгжүүлэх, олон улсын хэмжээнд дүгнэлт гаргах хүчин чадал, статустай итгэмжлэгдсэн лаборатори болгон үйл ажиллагааг нь өргөжүүлэн хөгжүүлэхээр ажиллаж байна.

Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл



Петрочайна Дачин Тамсаг компанийн олборлож буй түүхий тосны Монголын талд ногдох хэсгийг ашиглан Дорнод аймагт тухайн бүс нутгийн хэрэглээг хангах бага оврын үйлдвэр байгуулах, Дэд бүтэц, газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ, газарзүйн байршил, тээвэрлэлтийн нөхцөл зэрэг хүчин зүйлүүдээс хамааруулан импортын болон дотоодын түүхий эдэд тулгуурласан томоохон хүчин чадал бүхий боловсруулах үйлдвэрийг төвийн бүсэд буюу Чойр, Сайншанд орчимд барих гэсэн хувилбаруудыг сонгон энэ чиглэлээр судалгаа хийх, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, гадаадын туршлагатай компаниар хөндлөнгийн дүгнэлт гаргуулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. Мөн БНХАУ-ын Тянжин боомтод эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулагдаж буйтай холбогдуулан Кувейт, Эмират зэрэг арабын орнуудаас хөнгөлөлттэй нөхцлөөр авах түүхий тосыг тус чөлөөт бүсэд боловсруулан бүтээгдэхүүн авахаар тохиролцон эхний шатны ажлуудыг эхлүүлээд байна.

Эрдэс баялаг, эрчим хүчний яамнаас салбарын эрдэмтэд, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулсан Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг гаргахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хэсэг Монгол Улсад байгуулагдах үйлдвэрийн байршил, хүчин чадал, хэтийн төлөвийн талаар асуудал боловсруулан шийдвэрлүүлэх юм.

Шингэрүүлсэн шатдаг хийн талаар

Монгол Улс эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор ахуйн хэрэгцээ болон автомашиныг шингэрүүлсэн шатдаг хийгээр хангах сүлжээг бий болгон хөгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас “Шингэрүүлсэн шатдаг хий” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх үйл ажиллагаа явагдаж байна. Одоогийн байдлаар шингэрүүлсэн шатдаг хийн бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий Юнигаз, Горгаз, Дашваанжил, Дорноговь аймагт Монгазсервис, Ховд аймагт Эрдэнэ-Өлзий компаниуд ОХУ, БНХАУ, БНСУ зэрэг улсаас шингэрүүлсэн шатдаг хийг

импортолж

байна.

Шингэрүүлсэн шатдаг хийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчинг тодорхой болгон боловсронгуй болгох шаардлагатай байгаа юм.

Газрын тосны бүтээгдэхүүний хангамж


Он	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Нийт	441,438	550,995	563,593	607,281	639,032	884,103	779,593

Манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2005 онд нийт 563.6 мянган тн, 2006 онд 607.3 мянган тн, 2007 онд 639.0 мянган тн, 2008 онд 884,1 мянган тн, 2009 онд 779.5 мянган тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон. 2009 оны импортыг 2008 онтой харьцуулахад 104.5 мянган тонноор буюу 11.8 хувиар буурсан байна.


ГТБ-ний импортын бүтэц 2009 он

2009 онд нийт импортын 93.73 хувийг ОХУ-аас, 4.44 хувийг БНХАУ-аас, 1.08 хувийг Казакстанаас, 0.65 хувийг БНСУ-аас, 0.11 хувийг бусад улсаас тус тус импортлосон болно. Үүний 24.1 хувийг А-80 автобензин, 17.36 хувийг АИ-92,95,98 автобензин, 53.07 хувийг дизелийн түлш, 9.02 хувийг бусад бүтээгдэхүүн эзэлж байна

ГТБ-ний импортын бүтэц 2009 он




ГТБ-ний импорт, худалдаа эрхлэж буй аж ахуй нэгжүүдийн зах зээлд эзлэх хувь хэмжээ



№	Аж ахуй нэгжүүд	Дүн /тн/
1	Магнай трейд ХХК	174,221.5
2	НИК ХК	110,658.4
3	Петростар ХХК	58,852.2
4	Шунхлай ХХК	64,433.6
5	УБТЗ Х Э Г Н Х	57,671.3
6	Содмонгол Групп ХХК	44,926.8
7	Жаст-Ойл ХХК	42,460.8
8	Монпетекс ХХК	39,965.3
9	Петрожайна Дачин Тамсаг ХХК	32,442.0
10	Петровис ХХК	23,707.0
11	Петрокамп ХХК	17,105.6
12	Эрдэнэт Вйлдвэр ХХК	16,245.6
13	А-жет лимитед ХХК	13,981.9
14	Алхана трейд ХХК	12,969.5
15	Ойн бирж ХХК	12,372.7
16	Бусад	57,578.8
	Нийт	779,592.7

Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээний дийлэнхи хэсгийг ОХУ-ын “Роснефть” НХН-ийн Ангарскийн нефть боловсруулах үйлдвэрээс импортлодог бөгөөд 2009 оны байдлаар жилд 10 мянган тонн бүтээгдэхүүнээс дээш импорт хийдэг 15 аж ахуй нэгж байна.

ГТБ-ний импортын бүтэц 2009 он



№	Боомт	Дүн /тн/
1	Сэлэнгэ	679,261.8
2	Боршоо	21,281.7
3	Эрэнцав	16,152.8
4	Бичигт	14,318.6
5	Буянт-Ухаа	13,242.9
6	Замын-Үүд	12,100.2
7	Баянхошуу	11,855.8
8	Цагааннуур	8,990.7
9	Ярант	2,120.0
10	Алтанбулаг	251.0
13	Шивээхүрэн	13.3
14	Гашуунсухайт	3.4
15	Хавирга	0.5
	Нийт	779,592.7

Монгол Улсын ГТБ-ний 87,1%-ийг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт, 2,1%-ийг Дорнод

аймгийн Эрэнцав боомт, 1.6%-ийг Дорноговь аймгийн Замын-Үүд боомтоор тус тус төмөр замын дагуу импортлож байна. Бусад боомтын импорт автозамын дагуу хийгдэж байна.



ОХУ-ын “Роснефть” НХН-ээс 2010 оны 1 сард нийлүүлэх газрын бүтээгдэхүүний хилийн үнэ Н-80 автобензин 694 ам.доллар, Р-92 автобензин 709 ам.доллар, дизелийн түлш 768 ам.доллар болж өмнөх сартай харьцуулахад дундажаар 12 гаруй хувиар буурсан тул Монгол Улсын Засгийн газрын 2010 оны

1 дүгээр сарын 20-ны 14 дүгээр тогтоолын дагуу газрын тосны бүтээгдэхүүний гаалийн татвар 5% байхаар сэргээж, нэг тонн бүтээгдэхүүнд ногдуулах ОАТ-ын хэмжээг А-80 автобензинд 120 000 төгрөг/тонн, Аи-92 автобензинд 170 000 төгрөг/тонн, дизелийн түлшинд 30 000 төгрөг/тонн байхаар тогтоож, баруун аймгуудын хилийн боомтуудаар импортлох газрын тосны бүтээгдэхүүний Онцгой албан татварыг “0” хэмжээтэй байхаар тогтоосон.

2010 оны 4 дүгээр сард өмнөх сартай харьцуулахад Н-80 автобензины үнэ 51\$, Р-92 автобензины үнэ 43\$-аар тус тус өссөн, харин дизелийн түлшний үнэ 24\$-аар буурсан. Тухайн сард ам.долларын ханш суларч газрын тосны бүтээгдэхүүний өртөг буурсантай холбогдуулан нэг тонн бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварын хэмжээг Н-80, Р-92 автобензины хувьд хэвээр, харин дизелийн түлшинд 115000₮ хүртэл буюу 85000₮-өөр нэмэгдүүлэхээр Засгийн газрын 2010 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлээд байна.

2010 оны 5 дугаар сард Наушки боомтоор Монгол улсад нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнэ Н-80 автобензин 800 ам.доллар, Р-92 автобензин 875 ам.доллар, дизелийн түлш 826 ам.доллар болж 31-76 ам.доллараар нэмэгдээд байна.

Газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэл

Газрын тосны салбарын хууль, эрх зүйн орчинг сайжруулах, Газрын тосны салбарын эрчимтэй хөгжлийг хангахад чиглэсэн хууль эрх зүйн таатай орчныг төгөлдөржүүлж, төрийн зохицуулалтын үр ашгийг дээшлүүлэх, “Газрын тосны тухай” хууль, “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хууль, тэдгээр хуулийг хэрэгжүүлэх журам, дүрэм, зааврыг шинээр батлагдсан бусад хууль, тогтоомжид нийцүүлэх, боловсронгуй болгох,

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, техник, технологи ажиллагааны аюулгүй байдлыг хангуулахтай холбогдсон стандарт, журам, норм, дүрмийг боловсруулах, хянах, шинэчлэх,

Газрын тосны геологийн судалгаа, хайгуулын ажлыг эрчимжүүлэн ордыг ашиглалтанд шилжүүлэх, олборлолтыг нэмэгдүүлэх,
Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар шинээр БХГ байгуулах, үндсэн нөхцөлийг тохирч үзэглэсэн БХГ-үүдийг Монгол улсын Засгийн газраар батлуулах, Хайгуул хийж байгаа бусад талбайд газрын тосны нөөцийг тогтоох, Тосон-Уул, Цагаан-Элсний ордыг ашиглалтанд шилжүүлэх, газрын тосны ордын ашиглалттай холбогдсон дэд бүтцийг барьж байгуулах,
Үйлдвэрлэлийн олборлолт эхлэх үед цахилгаан эрчим хүчээр хангах, зам тавих, түүхий тос цуглуулах, хадгалах, урьдчилсан боловсруулалт хийх ил байгууламж барих, Тосон-Уулын ордоос БНХАУ-ын Сүрэн нуурын тос хүлээн авах байгууламж хүртэл 320 км түүхий тос дамжуулах хоолой барих төслийг боловсруулах,

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах,
Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг хангах хүчин чадалтай, үйлдвэрлэх бүтээгдэхүүн нь стандартын шаардлагад нийцсэн газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжих, Монгол Улсад байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийг яаралтай гаргах, Олборлох газрын тосны хэмжээ, нөөцөд тулгуурлан, монголын талын хөрөнгийн оролцоотой газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах асуудлыг шийдвэрлэх, Газрын тосны бүтээгдэхүүнээр тогтвортой хангах, Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг харьцангуй тогтвортой байлгахын тулд нийлүүлэгч талтай Засгийн газрын түвшинд хэлэлцээ хийж, тохиролцож байх, татварын зохицуулалт хийх,
Гуравдагч орнуудаас газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн импортлох чиглэл баримтлах, Кувейт, Катар, Эмират болон БНКазакстан Улсаас худалдаж авахаар урьдчилан тохироод буй түүхий газрын тосыг худалдан авах, тээвэрлэх, боловсруулах үйл ажиллагааг цогцоор шийдвэрлэх,
Газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах агуулах, сав барих хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, барьж байгуулах,
Хилийн боомтуудаар газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж, чадавхийг дээшлүүлэх,
Замын-Үүдийн шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөтгөх,

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, бүс нутгийг хөгжүүлэх,
Газрын тосны хайгуул, олборлолтын үед болон ордыг ашиглаж дууссаны дараа хүрээлэн буй орчны экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нөхөн сэргээлтийн ажилд төрөөс тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх,
Газрын төрх байдлын хянан магадлагаа, мониторинг хийлгэж, нөхөн сэргээх ажлыг холбогдох стандарт, журмын дагуу гүйцэтгэх, нөхөн сэргээлтийн төсөл хэрэгжүүлдэг үндэсний мэргэжлийн байгууллага бий болгох,
Газрын тосны салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах,

мэргэшүүлэх.

Салбарын боловсон хүчнийг бэлтгэх сургалтын хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, гадаад, дотоодын их, дээд сургуулиудад мэргэжилтэн бэлтгэх, төрийн сан болон бусад орны Засгийн газрын тэтгэлэгээр сургах салбарын оюутны тоог нэмэгдүүлэх, боловсон хүчин давтан сургах, мэргэжил ур чадварыг нь хөгжүүлэх, газрын тосны салбарт эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн ажилчдыг бэлтгэх замаар гадаадаас авах ажиллах хүчний тоог тууштай бууруулах,

Эрдэс Баялаг Эрчим Хүчний Яам Хэвлэл Мэдээллийн Алба